



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№250 /459/

2022.01.19

Цаг үе, үйл явдал

Ж.БОЛДБААТАР:АЛДАА ДУТАГДАЛ ГАРГАСАН БОЛ ЯМАГТ ТҮҮНЭЭСЭЭ СУРАЛЦАЖ БАЙХ ХЭРЭГТЭЙ



Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлүүд хуралдаж 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээгээ тайлагнасны зэрэгцээ 2023 оны бодлого, зорилгоо хэлэлцэн тодотголоо.

БХЯ-ны "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл" нь 2023 онд төрийн албан хаагчийн манлайлал, үлгэр дуурайллыг сайжруулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хууль дүрмийг сахих зан чанарыг төлөвшүүлэх, байгууллага, хамт олны ёс зүйтэй, зөв соёлыг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тус хуралдаанд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар тэргүүтэй БХЯ түүний харьяа байгууллагуудын Төрийн албан хаагчийн ёс зүйн

зөвлөлийн дарга нар оролцлоо.

Энэ үеэр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар хэлсэн үгэндээ "Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн дагуу ёс зүйн зөвлөлийг байгуулснаас хойш хоёр жилийн хугацаанд бид бүхэн уг зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлж харьяа байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, нэг бодлого, нэг зорилго, зорилтын дор нэгдэж чадсан. Үүний томоохон жишээ нь АТГ-аас уламжлал болгон жил бүр төрийн яам, агентлаг, нийслэл, орон нутгийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд хийдэг шударга байдлын үнэлгээгээр Батлан хамгаалах салбар 2021 онд Төрийн захиргааны төв байгууллагуудын хэмжээнд дунджаас доогуур үнэлгээтэй байсан бол 2022 онд бусад яамдыг тэргүүлсэн" гэж онцлоод энэ

эрчээ алдалгүй, алдаа дутагдал гаргасан ч ахин давтахгүй ямагт түүнээсээ суралцаж байхыг захин нийт бие бүрэлдэхүүнд дараах үүрэг чиглэлийг өгсөн юм.

Үүнд;

- Цэргийн алба хаагчдад хамааралтай хууль тогтоомж, дүрэм журмыг сайтар сурталчлан таниулах
- Цэргийн алба хаагчдын ёс зүйг дээшлүүлэх нөлөөллийн аяныг тогтмол зохион байгуулах
- Ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах
- Ёс зүйн зөвлөл зөрчил дутагдал гаргасан тохиолдолд нэн даруу шаардлагатай арга хэмжээг авч гаргасан алдаа дутагдлыг засаж залруулах зэрэг үүрэг чиглэл өгсөн юм.

Ө.НАСАНТОГТОХ

ЦЭРГИЙН ЧУУЛГЫН ХАРВААЧИД "ТЭРГҮҮН БАЙР"-ЫН ЭЗДЭЭР ТОДОРЛОО



Мэргэжлийн урлагийн байгууллагуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Шагайн харваа"-ны тэмцээнийг энэ удаад Дархан хотын "Залуучууд театр"-ын хамт олон амжилттай зохион байгуулж шилдгийн шилдгүүдэд тодрууллаа.

Монголын биет бус соёлын өв болсон шагайн харвааг өргөн дэлгэр сурталчлах, үндэсний спорт тоглоомыг мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн дунд дэлгэрүүлэх, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий энэхүү тэмцээн "Багийн харваа", "Хувийн цуваа харваа" гэсэн 2 төрлөөр хот хөдөөгийн театр чуулгуудын нийт 11 багийн 90 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдсөн байна.

Энэхүү тэмцээнд Улсын мэргэн – 9, Аймгийн гоц мэргэн – 26 оролцсон бөгөөд Аймгийн гоц мэргэн Г. Ганцогт ахлагчтай ЦДБЭЧ-ын баг тамирчид "Тэргүүн байр"-т шалгаран "Шилжин явах цом"-ын эздээр тодорч амжилтаа бататган, цэц мэргэнээ гайхууллаа.

Энэ удаагийн аварга шалгаруулах тэмцээнд ЦДБЭЧ-ын баг тамирчид 3 дахь удаагаа "Тэргүүн байр"-т шалгарсан бөгөөд "Шилжин явах цом"-ыг үүрд хадгалах эрхийг авч байгаа юм.

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-21	-35

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.480	3.485
EUR	3.775	3.795
CNY	511	515
RUB	48.80	49.30
JPY	27.10	27.30
KRW	2.86	2.90

ЗУРХАЙ

2022.01.19 / ПҮРЭВ ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 27

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал: Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх: 08.35-17.30
Барилдлага: Үл зохилдох
Шүтээн барилдлага: САНСАР

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олодох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД


Тохиолдол
Нийт: 672,330,178

Эдгэрсэн
Нийт: 643,783,758

Нас барсан
Нийт: 6,736,578

Цахим шууданд

ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН УАШТ-Д...



эрэгтэй 9 жин, эмэгтэй 9 жинд нийт 54 медалийн төлөө өрсөлдлөө. 2023 оны УАШТ-нд БХЯ-ны харьяа Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны Ахлах дэслэгч Ч.Март дасгалжуулагчтай хүндийн өргөлтийн баг тамирчид 9 алтан медаль, 3 мөнгөн медаль, шагналт байранд 2 тамирчин шалгарч, багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.

Энэ удаагийн УАШТ-нд ОУХМ Б.Эрдэнэзул, Г.Ууганбаатар, А.Амартөгс нар нь Монгол улсын дээд амжилтыг огцом, түлхэлттэй, нийлбэр дүнгээр шинэчилсэн.

АЛДАР СПОРТ ХОРОО

Хүндийн өргөлтийн 2023 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 01 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд УБ хотын Хан-Уул дүүрэгт байрлах Stepper Arena-Мөсөн өргөөд зохион байгуулагдлаа. Тус тэмцээн 16 багийн 130 гаруй тамирчид

ЖҮДО БӨХИЙН 2023 ОНЫ НАСАНД ХҮРЭГЧДИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН...



Жүдо бөхийн 2023 оны насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Монгол бөхийн өргөөнд 1 дүгээр сарын 14-нөөс 16-ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Улсын аварга шалгаруулах

тэмцээнд 34 байгууллага, клубын 283 тамирчин оролцсон. Тус тэмцээнд Алдар спорт хорооны баг тамирчид 4 алт, 4 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцож багаараа тэргүүн байр эзэллээ.



Тэмцээний 3 дахь өдөр Холимог багийн 9 дэх удаагийн Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнд 12 баг орсоноос "Алдар" спорт хорооны баг тэргүүлж тэргүүн байр эзэллээ.

Цаг үе, үйл явдал

ҮЗЭСГЭЛЭНГ БУУХААС НЬ ӨМНӨ АМЖИЖ ҮЗЭЭРЭЙ



Үзэсгэлэнгийн үзмэрийг цувралаар толилуулж байна.

#Монгол_цэргийн_музей
#ШУАийн_Археологийн_хүрээлэн
#Талын_морьтон_дайчид_үзэсгэлэн

Монгол цэргийн музей, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хамтран зохион байгуулсан "Талын морьтон дайчид" үзэсгэлэнг 01 дүгээр сарын 30 хүртэл Монгол цэргийн музейд зохион байгуулж байна.


Тус үзэсгэлэн нь Чингис хааны хүндэтгэлийн хэсэг, Морьт цэргийн аяны хангалт, хувийн бэлтгэлийн нөөц болох зэр зэвсгийн түүхэн хөгжлийг илтгэх үзмэрүүд, монголчуудын аж ахуй соёл, морины тоног хэрэгсэл, орчин үеийн дижитал технологи гэсэн хэсгээс бүрдэнэ.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагддаг Монголын эзэнт гүрний үе буюу XIII-XIV зууны үед хамаарах цэрэг эрсийн агсамж хэрэглэлтэй холбогдох олдворыг үзэгчдэд анх удаа дэлгэн үзүүлж байгаагаараа онцлогтой юм.

Үзэсгэлэнгээр өгүүлж буй түүх, үзмэр эд өлгийн талаар үзэгчид гар утсаараа QR код уншуулж мэдээлэл авах, VR дижитал төхөөрөмжөөр бодит мэдрэмжийг мэдрэх боломжтой.



“ЗӨВ ХАНДЛАГА-ЗӨВ МАНЛАЙЛАЛ” СЭДЭВТ СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Зэвсэгт хүчнээс 2023 оныг "Залуу офицеруудын манлайллын жил" болгосонтой холбогдуулан БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхан офицер, ахлагч, ажилтан албан хаагчдадаа энэ төрлийн сургалт, нөлөөллийн ажлуудыг явуулж байна.

Энэ хүрээнд Дорнод аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тус ангийн ажилтан албан хаагчдад "Зөв хандлага-Зөв манлайлал" сэдэвт мэргэжил, арга зүйн сургалтыг

хоёр өдрийн туршид зохион байгууллаа. Сургалтаар ажлын байрны онцлог, манлайлал, харилцаа хандлага, эерэг дулаан уур амьсгал, бүтээлч сэтгэлгээ, үүрэг гүйцэтгэл зэрэг олон сэдвээр мэдээлэл өгч, дадлагын ажил гүйцэтгүүлэв.

Мөн сургалтад хамрагдсан ажилтан албан хаагчдын олонх нь бүсгүйчүүд байсан учир гэр бүл дэх эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо, хайр халамж, үр хүүхдүүдийн хүмүүжил, залуу хосуудын итгэлцлийн талаар ч ярилцсан юм.

АХЛАГЧ Т.ЗУЛБАЯР ТОХИЛОГ АМИНЫ ОРОН СУУЦТАЙ БОЛЖЭЭ



Нийслэлийн Онцгой байдлын газраас алба хаагчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Мөрөөдөл биелдэг" арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ажээ.

Тэд энэ удаадаа аврах

ангийн механик-жолооч, ахлагч Т.Зулбаярыг сонгож, хашаа байшинг нь орчин үеийн халаалтын систем бүхий тохилог амины сууц болгон засварлаж өгсөн байна.

Ахлагч Т.Зулбаяр нь онцгой байдлын албанд 6 дахь

жилдээ ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд 180 удаагийн аюулт үзэгдэл, ослын дуудлагаар үүрэг гүйцэтгэж, 45 иргэний амь насыг авран хамгаалж, 12 буцалтгүй нэрвэгдэгчийг ослын голомтоос гаргажээ.